

ОХУ-ЫН БҮС НУТГИЙН БОДЛОГО БОЛОН МОНГОЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

*М.Татьяна**

Өнөөдөр Монголын талаар баримтлаж буй ОХУ-ын бодлого нь түүний АНДБ-ийн бодлоготой шууд холбоотой юм. Оросын ЗХА-д явуулж буй бодлоготой нягт уялдаа холбоотой Сибирь, Алс Дорнодыг хөгжүүлэх бодлогод Монгол Улс тэргүүлэх байр суурь эзлэж байна.

2007 оны 3-р сарын 27-нд ОХУ-ын Бүс нутгийн хөгжлийн яаманд Алс Дорнод, Байгал нуурын бүсийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн Үзэл баримтгал хэлэлцэв. Тус Үзэл баримтлалд Оросын томоохон хоёр макро бүс болох Алс Дорнод болон Байгал нуурын арын бүсийн стратегийн чиглэлийг тодорхойлж, урт хугацааны хөгжлийг тодорхойлсон үйл явдал, гадаад орнуудын нөлөө, дотоодын нөхцлийг нарийн заажээ. Макро бүсийн хөгжлийн явцад урт хугацааны чанартай эрсдэл, зорилго, зорилтыг тус бүс тодорхойлж, тэргүүлэх хөтөлбөр, хөгжлийн төслүүд орсон. Мөн Сибирь, Алс Дорнодыг түүхэн явцад эзэмшсэн үйл явдал, орон зайн зохион байгуулалт, хүн амын байдлыг АНДБ-ийн орнуудтай харьцуулж, тээвэр, эрчим хүч, орон сууц, санхүү, боловсролын салбарын байдлын анализ орсон. Тус Үзэл баримтлалыг хэлэлцэж, хэрэгжих механизмын талаар цаашид детальчилсан боловсруулалт хийж, Алс Дорнодын хувийн бизнесийн оролцоог нэмэгдүүлэх, эдийн засгийн салбар, орон нутгийн стратегийн чиглэлийг тодорхойлохоор шийдсэн.

Санкт-Петербургийн Бүс нутаг, инновацийн төвийн захирал, улс төрийн ухааны доктор И.В.Бойко-ын тэмдэглэснээр, тус бүс нутаг нь цаашид Оросоос холдож, АНДБ-ийн орнуудаар “залгигдах” аюултай гэдгийг харуулж, эдгээр бүсүүдийн давуу тал, стратегийн зорилтонд хүрэх механизм, саадыг арилгах талаар тодорхой заагаагүй гэжээ. Мөн гол дутагдал нь Алс Дорнод, Байгал нуурын арыг Оросын бүс нутаг гэсэн үүднээс хөгжлийн стратегийг боловсруулж чадаагүй бөгөөд зөвхөн АНДБ-ийн орнуудын түүхий эдийн нийлүүлэгчээр тодорхойлж, ингэснээр энэ макро бүсийг эдийн засгийн хувьд Оросоос тусгаарлах үндэс болно гэж шүүмжилж, “тус бүсийг Бүс нутгийн хөгжлийн яам нь өөрөө ОХУ-ын үндсэн газар нутаг биш гэж тодорхойлсон нь үндсэн болон үндсэн бус нутаг газартай улс хүчтэй, өрсөлдөх чадвартай байж чадах уу?” гэж тэмдэглэв. Байгал нуурын бүсийн тухай анализ дэлгэрэнгүй ороогүй бөгөөд БНХАУ-ын хүчин зүйлийг хэт их заасныг тэрээр тэмдэглэсэн.

* М.Татьяна - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Тус Үзэл баримтлал нь 2006 оны 12-р сарын 20-ны өдөр ОХУ-ын Үндэсний Аюулгүй байдлын баталсан “Алс Дорнодын Холбооны тойргийн нутаг дэвсгэр дээр үндэсний аюулгүй байдлыг хангах тухай” шийдвэрийн дагуу 2007 оны 2-р сарын 9-ний өдөр ОХУ-ын Засгийн газрын даргын гаргасан захирамжийн 1-р зүйл болон 2007 оны 1-р сарын 27-ны өдөр ОХУ-ын Ерөнхийлөгчийн баталсан “Алс Дорнод, БН Буриад Улс, Эрхүү болон Чит мужийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн асуудлаар Улсын комисс байгуулах тухай” 87-р дугаар тогтоолын дагуу Оросын Бүс нутгийн хөгжлийн яам болон гүйцэтгэх засаглалын холбооны байгууллага, субъектүүдийн засаглалын байгууллага, төрийн бус байгууллагуудын хамтын хүчээр боловсруулагдаж эцсийн хувилбар хараахан батлагдаагүй байгаа юм. Үүнтэй холбогдуулан нэг зүйл дурьдвал, Байгал нуурын арын бүсийг өмнө нь Алс Дорнодын стратегид багтаан үзэж байсан юм. 2008 оны 3-р сарын 1-ний өдөр Агийн Буриадын үндэсний тойргийг Чит мужийн бүрэлдэхүүнд оруулсны дараа, Чит муж нь Байгал нуурын арын хязгаар гэж нэрлэгдэж, Сибирийн Холбооны тойргийн бүрэлдэхүүнээс гаргасан юм. Байгал нуурын арын хөгжлийн тухай олон тооны материал дотор Буриад, Эрхүү муж орсон байдаг нь хачирхалтай. Учир нь Буриадын нутаг бол Байгал нуурын ар нутагт оршдог бол, Эрхүү муж нь Байгал нуурын өвөр нутагт байрладаг нь тодорхой юм. Харин одоо эдгээр субъектүүдийг нэгтгэж Байгал нуурын бүс гэж нэрлэх болжээ.

Түүхийн явцад Монгол Улс нь Орос, Хятадын харилцаанд чухал байр суурь эзэлдэг. Бүс нутаг шинжлэх ухаан нь Орост сүүлийн үед хөгжиж эхэлсэн харьцангуй шинэ салбар билээ. Регионалистикийн онолын дагуу улс орны бүсчилсэн хөгжлийн бодлого нь түүний бүс нутгийн гадаад бодлогыг тодорхойлдог. Орос улс нь өргөн уудам нутаг дэвсгэр, байгаль, цаг уурын нөхцөл, газрын нөөц, үндэстэн, хүн амын хувьд ихээхэн ялгаатай бөгөөд дэлхийд хамгийн олонд тооцогддог нийт 89 субъекттэй холбооны улс юм. Үүний улмаас бүсчилсэн хүчтэй бодлого явуулж улс орныг удирдан хөгжүүлэх шаардлагатай тулгарсан. Мөн Оросын нэг онцлог бол зарим субъектүүд нь холбооны төдийгүй, дэлхийн түвшинд байгалийн нөөцөөр тэргүүлэх байр суурийг эзэлж хойд болон дорнод хэсэгт байрладаг. Төрийн “зөв зохицуулалтын” үр дүнд эдгээр “түүхий эдийн бүсүүд” нь хурдацтай хөгжсөн гэж үздэг.

Эдгээр бүсүүд маш ховор нөөцтэй, өндөр ашигтай боловч үйлдвэрлэлийн өндөр зардал, олборлолт, ашиглалтын хүнд нөхцөлтэй юм. Харин эл бүсүүдийн хүн ам суурьших нөхцөл бүрдээгүй гэж шинжээчид үздэг юм байна. Иймээс ОХУ-ын Засгийн газар төрийн “зөв зохицуулалт” хийж, “түүхий эдийн бүсүүдийг” хөгжүүлэхдээ

холбооны нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын онцлогийг харгалзан газрын нөөц ашиглах систем шинээр бий болгох гэсэн тулгамдсан асуудлуудтай тулгарсан.

Бүсчилсэн хөгжлийн төрийн бодлогын хүрээнд маш олон арга хэмжээ авч эхэлсэн боловч эхний ээлжинд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь тийм ч амжилттай байж чадаагүй юм. Орос нь Европын бүсчилсэн бодлогын туршлагыг шууд хуулбарлан, өөрийн субьектүүдийн онцлогт тохируулан хэрэглэж чадаагүй. Баримталж байсан бүсчилсэн хөгжлийн бодлогын гол зорилго нь бүсүүдийн хоорондох эрс ялгаатай нийгэм-эдийн засгийн түвшинг тэгшитгэх, нэг түвшинд хүргэх талаар олон жилийн турш арга хэмжээ авсан ч амжилтанд хүрээгүй. Ингээд Сибирь, Алс Дорнодыг хөгжүүлэх тусгай стратеги шинээр боловсруулж, шат дараалсан арга хэмжээнүүдийг авч эхэлсэн шалтгаан нь Оросын олон мужууд гадаад оронтой хил залгадаггүй, субьект хоорондын эдийн засгийн харилцан үйлчлэл үр ашиг багатай учраас цаашид субьектүүдийг хооронд нь нэгтгэж, гадаад харилцааг нь чиглүүлэхэд гол зорилго оршино. Энэхүү өгүүлэлд одоогоор Сибирийн Холбооны тойрогийн /СХТ/ бүтцэд багтаж буй Монгол Улстай хил залгаа Эрхүү муж, Алтайн хязгаар, Буриад, Тува, Алтайн БНУ-ууд болон Алс Дорнодын ХТ-ийн Байгал нуурын арын хязгаар буюу хуучнаар Чит мужийн Сибирийн Холбооны тойрог болон Байгал нуурын арын бүсийн хүрээнд тус тус хамтын ажиллагааг авч үзсэн юм.

Оросын атомын салбарын түүхий эдийн хэрэгцээг удаан хугацаанд тогтвортой хангах зорилгоор 2006 онд хэрэгжүүлсэн “Оросын уран” тусгай хөтөлбөрийн дагуу холбооны 9 бүсэд холбооны төсвөөс нийт олгосон санхүүгийн зардлын 53%-ийг өгснөөр онцгой ач холбогдолтой бүсүүдийн нэгд нь Чит муж орсон юм. Ураны хайгуулын ажил Байгалын ар, Дорнод Саян, Якутын өмнөд зүгт хийгдсэн. ЗХУ задарсны дараа ураны илэрсэн орд газруудын 90% ОХУ-ын хилийн цаана үлдэж, Оросын ураны нөөц нь 2015 онд дуусах талдаа орох тул, ураны салбарыг хөгжүүлэх нэн шаардлагатай болов. Оросын ураны дотоодын хэрэгцээ болон экспортын хэмжээ нь нийлээд 1 жилд 9000 тонн байдаг бол, өнөөдөр Чит мужийн Приаргуны үйлдвэр нь дөнгөж 2500 гаран тонн үйлдвэрлэж байна.

2007 оны 12-р сард болж өнгөрсөн ОХУ-ын Газрын нөөцийн холбооны агентлагийн хуралдаан дээр холбооны бүсүүдэд хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлж, үнэт болон өнгөт металл, ураны түүхий эдийн хайгуулыг тэргүүлэх чиглэл болгосон. Мөн үед “Оросын уран” төслийн дагуу Орост хэд хэдэн орд газруудыг илрүүлсний үр дүнд, үүнээс Монгол Улстай хил залгаа Чит мужид уран олборлох “Горное” компани нь Горное и Берёзовое 2 орд газар, “Оловская ГХК” компани нь

Оловское орд газар нийт 3 орд газар ашиглахаар болов. Тус хоёр компани нь “Ростатом” хэмээх Атомын эрчим хүчний Холбооны агентлагын гол байгууллагуудын нэг болох “Атомредметзолото”-ын охин компаниуд юм. “Горный”, “Березовый” хэмээх ордуудын нийт нөөц нь 8700 тонн, Оловскийнх 12800 тонн. “Атомредметзолото” нь Росатомын уран олборлох гол байгууллага бөгөөд Оросын нутаг дэвсгэр дээр болон гадаадын оронд олборлолтын үйл ажиллагаа явуулах онцгой эрхтэй. “Атомредметзолото” нь ОАО “Атомэнергопром”-ын бүтцэд орж, ОХУ-ын уран олборлох салбарыг удирдаж, Казахстаны нутаг дэвсгэр дээр уран олборлох хамтарсан үйлдвэрүүдтэй юм.

ОХУ-ын Засгийн газрын дарга В.Зубковын урилгаар Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярын 2008 оны 4-р сард ОХУ-д хийсэн айлчлалын үр дүнд хоёр тал стратегийн түншлэлийг хөгжүүлэх, эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай тохиролцсон. Сүүлийн үед Монгол, Оросын харилцаа “шинэ түвшинд гарч, шинэ чанартай болж байна” гэж Оросын тал тэмдэглэв.¹ Оросын тал нь Монголд Атомын цахилгаан станцын барилгын Техник-эдийн засгийн төслийг боловсруулахад бэлэн байгаагаа мэдэгдэв. 2000 онд Орос, Монгол хоёр атомын эрчим хүчийг энх тайвны зорилгоор ашиглах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурсан. Атомын салбар дахь хамтын ажиллагаа нь ОХУ-ын Росатом, Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яамны хооронд 2007 онд байгуулсан Орос, Монгол хоёр орны нутагт ураны хүдрийн ордод геологийн хайгуул хийж, олборлож, боловсруулах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай протокол дээр үндэслэж байгаа юм.² Оросын тал нь Дорнод аймгийн сав газрын ураны орд газруудыг хамтран ашиглахыг хүсч байгаагаа нэг бус удаа илэрхийлсэн байна.

Монгол Улсын Засгийн газар зөвхөн түүхий эд нийлүүлэгч биш, боловсруулах салбарт хамтран ажиллаж, Монгол, Оросын аль алиных нь талд хамтарсан үйлдвэрлэл явуулах сонирхолтой байгааг Росатомын дарга С.Кириенко хоёр талын ашиг сонирхолд нийцнэ гэж үзэж байгаагаа илэн далангүй мэдэгдлээ.³ Ерөнхий сайд С.Баяр хамтарсан үйлдвэр байгуулах тухай саналыг дэвшүүлсэн юм. Монгол Улсын Ерөнхий сайд ОХУ-д айлчлал хийсний дараа, МАГАТЭ-д зочилсон юм.

Чит муж буюу Байгал нуурын арын хязгаарын нийслэл Чита хотын дараа ордог Краснокаменск хотноо Приаргуны уул уурхай-химийн үйлдвэр нь Росатомын өмч бөгөөд Орост уран боловсруулах цорын ганц үйлдвэр юм. Тус үйлдвэр нь уурхайн аргаар ураны болон уран-молибдены Стрельцов дахь 19 орд газруудад олборлолт хийж, илэрсэн нөөц нь 170 мянган тонн юм. Тус үйлдвэр нь 2006 онд 2,8 тонн уран олборлосон. Приаргуны үйлдвэр нь хүхрийн хүчил, манганы хүдэр, шохойн чулуу, шохой үйлдвэрлэхээс гадна, олон талын үйл

ажиллагаа явуулдаг том цогцолбор бөгөөд бүтцэд нь нүүрсний уурхай, дулааны, цахилгаан эрчим хүчний үйлдвэр, барилгын үйлдвэр, тээврийн компани, эрдэм шинжилгээний лаборатори, сургалтын комбинат, хөдөө аж ахуйн газар багтдаг. “Базановская” минерал ус нь “Оросын 100 нэртэй бүтээгдэхүүнээр” 1998, 2002 онд шалгарч, Горняцкий махны үйлдвэр нь Горбатовын нэрэмжит ОХУ-ын махны үйлдвэрлэлийн эрдэм-шинжилгээний институттэй хамтран ажилладаг онцлогтой бөгөөд чанарын тусгай зөвшөөрөлтэй махны бүтээгдэхүүн, хиам үйлдэрлэдэг.

2007 оны 6-р сард Росатомын дарга С.Кириенко тус үйлдвэрийн байдалтай танилцаж, ойрын хугацаанд ураны үйлдвэрийн хэмжээг 5000 тонн хүртэл нэмэгдүүлэх зорилго дэвшүүлж, Чит мужийн ураны нийт олборлолтын хэмжээ 6-6,5 тонн болгох төлөвтэй. 2004-2006 онд үйлдвэрийн гэнэтийн осол нь 20%-иар нэмэгдэж, үйлдвэрийн техник, технологийн хоцронгуй байдлаас шалтгаалан гарсан түймрийг унтрахад 10-30 цаг шаардлагатай байдаг.⁴ Иймээс техник, технологийн шинэчлэл хийх нь тэргүүний зорилго болохыг тэрээр тэмдэглэв.⁵

Иймээс ОХУ нь Монгол Улстай ураны салбарт хамтран ажилласнаар дэлхийн эрчим хүчний салбарт өөрийн байр сууриа улам бэхжүүлэх болно. Үүний зэрэгцээ Монгол Улсын хувьд өөрийн бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээл дээр гаргах боломж нээгдэх юм. ШХАБ-ын албан ёсны вэб-хуудаснаа Монголын ураны тогтоогдсон баялаг нь 60 мянган орчим тонн бол, Оросын мэргэжилтнүүдийн урьдчилсан тооцоогоор үүнийг нэг дахин илүү буюу 120-150 мянган тонн гэж нийтлэсэн байна. Албан ёсны мэдээгээр, Монголын ураны нөөц дэлхийн нөөцийн 10%-ийг эзэлдэг бол, Оросын ураны нөөц 14%⁶ буюу ойролцоогоор тогтоогдсон нөөцийн хэмжээ 615 мянган тонн бол, урьдчилсан тогтоогдоогүй нөөц нь 830 мянган тонн аж.

Иймээс ОХУ-ын ашиг сонирхол Монголд их байгаа нь ойлгомжтой. Мөн 2000 оны сүүлээр Аюулгүй байдлын Зөвлөлийн хуралд В.Путин үг хэлж, Оросын ТЭХЦ-ыг үндэсний эдийн засгийг хөгжүүлэх гол салбараар тодорхойлж, дунд хугацааны стратегийн хөтөлбөрт дэлхийд тэргүүлэх байр эзлэх зорилго дэвшүүлэн, үүнээс Оросын өнөөдөр, ирээдүй шалтгаалах юм гэжээ. ОХУ Гадаад бодлогын Үзэл баримтлалаа 2008 оны 7-р сарын 12-нд шинээр баталж, үүнд эрчим хүчний бодлогоо шинээр тодорхойлсон юм.⁷

Нөгөө талаас, цөмийн салбарт Монгол Улстай хамтран ажиллахыг зөвхөн Орос улс биш, Франц, Япон улсууд илэрхийлсэн.

Эрхүү муж нь Орос, Монголын харилцаанд стратегийн онцгой байр суурь эзэлж ирсэн бөгөөд хоёр талын худалдаа-эдийн засгийн эргэлтэнд тус муж нь 60%-ийг дангаар эзэлдэг үзүүлэлт нотолж байгаа юм. Монголын экспортын гол бүтээгдэхүүн нь шатахуун, түлш, харин сүүлийн жилүүдэд

мах, махан бүтээгдэхүүний хэмжээ эрс нэмэгдсэн. Харамсалтай нь Ковыктинскийн орд газраас АНДБ-ийн чиглэл рүү барих газрын тос, байгалийн хийн хоолойн Оросын талын анх дэвшүүлсэн төсөл нь Монголын УБТЗ-ын дагуу байсан боловч, Орос, Хятад, Монгол гурван орны хамтын ажиллагааны ЗХА-ийн интеграцийн хүрээнд хэрэгжих томоохон төсөл Хятадын талын дэмжлэгийг аваагүй юм.

БН Алтай Улс, Алтайн хязгаартай Монгол Улс нь Завхан аймгийн нүүрсний орд газрын олборлолтын салбарт хамтран ажилладаг. Эл субъектүүдэд Аялал-жуулчлал, сэргээн нөхөх онцгой бүс байгуулагдах ажил явагдаж байгаа учир, ойрын хугацаанд Монголын баруун аймгуудад ЭЗЧБ байгуулах нь ирээдүйтэй.⁸ Алтайн хязгаар нь Монголын зах зээл дээр гурил, будааны олон төрлийн бүтээгдэхүүний томоохон нийлүүлэгч билээ. Мөн Орос, Хятад, Монгол гурван орны 3 талын бүс нутгийн бодлого эрчимжиж байгаа тул, цаашид Алтайн хязгаараас Баруун Монголын нутгаар “Алтай” хэмээх газрын тос, байгалийн хийн хоолойг Хятад уруу гаргах зорилгоор хамтран оролцох боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Энэ асуудлыг тусгайлан авч хэлэлцэх нь зүйтэй болов уу. Мөн Оросын тал нь Асгатын мөнгөний орд газрыг хамтран ашиглах сонирхолтой гэдгээ илэрхийлсэн юм.

Буриадын хувьд гэвэл, тус субъект нь Зүүн Сибирийн үйлдвэрлэл харьцангуй хөгжсөн бүсэд ордог бөгөөд, Монгол Улстай үйлдвэрлэлийн салбараасаас гадна, хөдөө аж ауйн салбарт хамтран ажиллах бүрэн боломжтой. Монгол Улс нь Улаан-Үдийн нисэх онгоцны үйлдвэрээс нисдэг тэрэг авч байсан удаатай, цаашид ч авах сонирхолтой байгаа юм. Тус онгоцны үйлдвэр нь Орост төдийгүй, дэлхийд нэртэй үйлдвэр бөгөөд зарим орны нисэх онгоцны импортод давамгаалдаг юм. Улаан-Үдэд вагон, зүтгүүрийн засварын, усан онгоцны сэлбэгийн, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн, цахилгаан техникийн гээд тус тус үйлдвэрүүд байдаг. Мөн хоёр талын худалдааны уламжлалт бүтээгдэхүүн болох Монголын махны экспортыг нэмэгдүүлэх боломжтой юм. Оросын зах зээл дээр Европ, Латин Америкийн чанар муутай буюу малын халдварт өвчтэй мах ихээхэн импортлогдож, худалдаанд орсны дараа Оросын хорио цээрийн хяналтыг хангаагүй байсан нь нотлогдож, улмаар хүмүүсийн эрүүл мэндийг хордуулж шуугиан дэгдээх нь олон тохиолддог. Харин Монголын махыг Орост эрт дээр үеэс хэрэглэж мэддэг учир иргэдийн сайшаалыг хүлээн авч зүй ёсоор дээд зэрэглэлийн махны бүтээгдэхүүнд тооцогддог нь нууц биш билээ. Иймээс өнөөдөр Оросын зах зээл дээр “экологийн цэвэр бүтээгдэхүүн”-ийг дэмжих, сурталчлах, эрүүл хүнсний бодлого хэрэгжиж байгаа тул, Монголын махны чанарыг Оросын зах зээл дээр хүлээн зөвшөөрүүлэхдээ олон улсын стандарт бус, хоёр талын тусгай

хэлэлцээрээр баталгаажуулах шаардлагатай байгаа юм. Ийм арга хэмжээ авснаар “уламжлалт зарчим” дээр үндэслэсэн Оросын махны квотын хуулийн дагуу Эрхүү мужийн жишгээр, Сибирийн хэрэгцээнд Монголоос мах их хэмжээгээр орж ирэх болно.

БН Тыва Улсын геополитикийн онцгой байршил нь өнөөдөр түүнд ашгаа өгч эхлэж байгаа юм. Тыва нь Оросын “хямралтай, угийн хоцрогдмол” бүсийн хувьд холбооны төвөөс томоохон дэмжлэг авч, Элегестын коксжуулсан нүүрсний орд газрын ашиглалттай холбоотойгоор Кызыл-Курагино чиглэлийн 460 км урттай төмөр зам баригдаж эхэлсэн хийгээд үүнээс 80 км нь уулан дундуур гарч, 3150 м, 900 м-ын урттай 2 туннель баригдснаар “дэлхийн 8 дахь гайхамшиг”-аар тооцогддог Синьхай-Төвд гэсэн чиглэлийн Хятадын төмөр замын барилгаас ч нүсэр том барилга болно гэж үздэг. Ингэснээр Тыва нь холбооны татааснаас салж, эдийн засгийн гүн хямралаас гарна. Элегестын коксжуулсан “Ж” маркийн нүүрсний нөөц нь дэлхийд ховорт орж, үүнийг ашиглалтанд оруулснаар Орост 1-р байр эзэлж, дэлхийд 3-р байр эзлэх юм. 2000 онд баталсан “ОХУ-ын эрчим хүчний стратеги”-ийн дагуу⁹ 2020 он хүртэл хэрэгжих хугацаанд нүүрсний салбар гол байр эзлэх юм. Нүүрсний салбарын үйлдвэрлэлийн хэмжээ Оросын эрчим хүчний аюулгүй байдалд гол нөлөө үзүүлж, иймээс бүсүүдийг бүхэлд нь эрчим хүчээр хангахын тулд үр ашигтай, өрсөлдөх чадвартай нүүрсний үйлдвэрлэл бий болгох зорилго хэрэгжиж эхэлсэн. 1950-аад он дуустал эрчим хүчний гол эх үүсвэр нь нүүрс байсан бол, дахин сэргээгдэшгүй баялгийн нөөц дуусахад, ирээдүйд нүүрсний үе дахиад ирэхийг шинжээчид үздэг.

2015 онд буюу долоохон жилийн дотор Тыва нь Оросын түүхэнд анх удаа маш хурдан хугацаанд баян субъектүүдийн тоонд орохоос гадна, ОХУ-ын эдийн засгийн донор-бүс болон хувирах ажээ. Тыва нь 1944 онд ЗХУ-ын бүрэлдэхүүнд орж, Оросын нийт 89 субъектүүдийн дотор 88-р байр эзэлж буй.

Төмөр замын барилгатай холбоотой төсөлд Монголын баруун аймгуудын ашиг сонирхолыг тооцох нь зүйтэй болов уу. Орос, Монголын хамтын ажиллагааны үндэс нь болох дэд бүтцийн асуудал хөндөгдөж байгаа тул, баруун аймгуудыг Оросын Баруун Сибирьтэй холбох нь чухал юм. Мөн Тывагийн хурдацтай хөгжил нь Оросын бусад субъектүүдэд үлгэр жишээ болох байх гэж найднам.

Хоёр талын хамтын ажиллагааны геологи-хайгуулын салбарт жонш, цагаан тугалга, вольфрам, молибден, зэсийн хайгуулын ажилд цаашид хамтран оролцох боломжтой. Эрдэс баялгийн дундаас гол байр суурь эзэлдэг нь “Эрдэнэтийн овоо” бөгөөд түүний үндсэн дээр баригдсан УБУ “Эрдэнэт” нь Монголын экспортын гол бүтээгдэхүүн болж төсвийн ихэнхийг бүрдүүлдэг. Харамсалтай нь, зэсийн

баяжмалын экспорт зөвхөн Хятад уруу чиглэж, тэнд дараагийн үйлдвэрийн боловсруулалт хийгдэж байгаа юм. “Эрдэнэт” үйлдвэрийн 30 жилийн ойгоор Оросын талын мэдээлснээр, цаашид зэсийн баяжмалыг худалдан авч, эцсийн бүтээгдэхүүн гаргах санал дэвшүүлсэн нь ирээдүйтэй юм. Оросын тал мөн УБТЗ-ыг шинэчлэх, Тавантолгой, Оюутолгойн чиглэлээр төмөр зам барьж дэд бүтцийг бүрдүүлэх ажилд оролцох сонирхолтой гэдгээ мэдэгдэв.

Монгол Улс нь бие даан уул уурхайн салбарыг хөгжүүлэх санхүү болон технологийн хувьд боломж багатай бөгөөд ийм бэрхшээл дэлхийн олон орнуудад тулгарч байгаа юм. Уул уурхайн салбарт Үндэстэн дамнасан компаниудын үүрэг манлайлал чухал байдаг учир Монголын тал гадаадын томоохон компаниудын ашиг сонирхолуудыг татах сонирхолтой байна. Хил орчмын байрлалтай орд газруудын хувьд гэвэл, ОХУ-тай хамтран ажиллах нь Монголын хувьд стратегийн ач холбогдолтой бөгөөд ЗХА-ийн интеграцийн хүрээнд бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны ирээдүйтэй юм.

Үүний зэрэгцээ эдийн засгийн хамтын ажиллагаа хэвийн явагдахын тулд, хоёр талын худалдааны либеральчлалын асуудлыг шийдвэрлэх шаардлага урган гарч байна. Оросын БНХАУ-аас авдаг экспортын барааны бүтэц нь хөнгөн, арьс ширний үйлдвэр, үслэг, үнэт металл болон тэдгээрийн бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа голлодог бол Оросын эдийн засгийн хямралын үед хүн амын хэрэгцээг Хятадын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн бүрэн хангаж Орос-Хятадын харилцаа бие биенээ нөхсөн, харилцан ашигтай байсан гэж Оросын тал тэмдэглэдэг. Хятадаас импортлодог эдгээр бүтээгдэхүүнтэй ижил төстэй Монголын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүн нь Хятадынхаас чанараараа илүү боловч, харамсалтай нь, тарифын болон тарифын бус хязгаарлалтаас шалтгаалан Оросын зах зээл дээр нэвтрэх боломжгүй байдаг. Социализмын үед Орос нь Монголоос маш өргөнөөр нэхий дээл, хивс, савхин эдлэл, гутал, ноос, ноолууран бүтээгдэхүүн авч байсан бол, өнөөдөр Оросын төрийн зохицуулалтгүйгээр “ганзагын наймаа”-ны сувгаар Оросын зах зээл дээр гарсаар байна. Харамсалтай нь, Монголын үйлдвэрлэлийн 100% экологийн цэвэр түүхий эдээр хийгдсэн бараа, бүтээгдэхүүн нь Оросын зах зээл дээр чанар муутай Хятадын бараанаас хямд борлогдож, хэрэглэгчдийн сайшаалыг хүлээсээр байна. Ийм янзаараа үргэлжлэвэл Монголын эдийн засагт нэн хохиролтой юм. Хоёр талын худалдааны асуудал, тэр дотроо хил орчмын худалдааны асуудал тулгамдсан асуудлын нэг билээ. “Алтанбулаг” ЭЗЧБ нээгдсэнээр хил орчмын худалдааны асуудалд эерэг өөрчлөлт гарах боломжтой.

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан, эдүгээ ТУХН-ын гишүүн болон гишүүн бус орнууд нь ОХУ-ын хилийн уртын дагуу байгуулсан “сайн хөршийн бүсэд” /”пояс добрососедства”/ багтаж, өнөөдөр өөрийн бүтээгдэхүүнээ Оросын зах зээл дээр экспортлосоор л байна. Эдгээр орны хувьд, Орост нийлүүлэх экспорт нь төсвийнх нь бараг гол орлогыг бүрдүүлэхээс гадна, Оростой харилцаагаа тасалж, экспортын эх үүсвэр дутагдснаар эдийн засгийн гүн хямралд орж байсан түүхтэй. Иймээс ОХУ нь өөрийн хөрш орнуудын эдийн засгийг хяналтандаа авч, мөн БНХАУ ч гэсэн бүс нутгийнхаа томоохон орнуудын эдийн засагт нөлөө үзүүлдэг билээ. Монголын төсвийн ихэнх хэсгийг УБҮ “Эрдэнэт” бүрдүүлдэг жишээтэй.

Иймээс ОХУ АНДБ-д байр сууриа бэхжүүлэхийн тулд эрчим хүчний бодлого буюу “Их хоолойн эдийн засгийн бодлого”¹⁰ улам хүчээ авч байгаа тул, Монгол Улсыг хойд хөрш нь түлш эрчим хүчний салбарын түнш гэж сонирхож эхэлсэн гэж хэлж болно. Хоёр талын харилцаа шинэ шатанд гарч байгаа нь үүнийг нотолж байгаа юм. Үүний зэрэгцээ Монголын тал Оросын хурдацтай хөгжиж байгаа эдийн засгийг сонирхож, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, шинэ шатанд гаргахыг эрмэлзэж байна. Юуны түрүүнд, стратегийн түншлэл нь Монгол Улсын аюулгүй байдалд ач холбогдолтой. Мөн Монгол Улс, Оросын хувьд стратегийн ач холбогдолтой, баян, чинээлэг бүсүүдтэй хил холбох нь ЗХА-ийн бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд Монгол Улсын үүрэг роль үлэмж өсөх ач холбогдолтой.

2000 оны сүүлээр ОХУ-ын Аюулгүй байдлын Зөвлөлийн хурал дээр Ерөнхийлөгч В.Путин үг хэлж, *Түлш-эрчим хүчний цогцолбор /ТЭХЦ/-ыг үндэсний эдийн засгийг хөгжүүлэх гол салбараар тодорхойлж, мөн дунд хугацааны хөтөлбөрт дэлхийд тэргүүлэх байр эзлэх зорилго дэвшүүлэн, үүнээс Оросын өнөөдөр, ирээдүй шалтгаалах юм гэж онцлон тэмдэглэв. ТЭХЦ-ын байдлаас ЗХУ-ын үед ч улс хамаардаг байсан онцлогтой. ОХУ-нь өнөөдөр шинээр боловсруулж буй Алс Дорнод, Байгал нуурын бүсийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн Үзэл баримтлалдаа ТЭХЦ-ын баялгийн экспорт дээр түшиглэж байгаа юм. Нөгөө талаас, Оросын тал бусад орны нутаг дэвсгэр дээр ТЭХЦ-ын салбарт хамтарсан үйлдвэр байгуулах санал дэвшүүлэхдээ /жишээ нь, Казахстан, Украин зэрэг оронтой/ хамтарсан консорциумын хэлбэр илүүд үзэж байгаа юм. Дараагийн цуврал өгүүлэлд ОХУ-ын түлшийн үйлдвэрлэл, газрын тос, байгалийн хийн, нүүрсний, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн тухай тодорхой өгүүлж, дүгнэх хэсэгт нь Монгол Улсад үзүүлэх нөлөөг тус бүр авч үзнэ.*

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. <http://news.mymongol.com/print.asp?ID=6119>
2. <http://news.mymongol.com/page.asp?mmCategory=mongol&ID=6119>
3. Мөн тэнд.
4. Читинским предприятиям не хватает горноспасательных частей 19.01.2006
<http://www.obladm.chita.ru/news.php?date=19.01.2006>
5. <http://www.rambler.ru/news/russia/0/10484970.html>
6. Экономическая география России. Москва. ИНФРА-М. 2004.
7. Концепция внешней политики Российской Федерации.
<http://www.kremlin.ru/text/docs/2008/07/204108.shtml>
8. М.Татьяна. Оросын эдийн засгийн чөлөөт бүсийн тухайд. ОУС. 2007. №4.
9. Энергетическая стратегия России на период до 2020 года.
<http://www.minprom.gov.ru/docs/strateg/1/>
10. “Экономика Большой трубы” хэмээх томьёоны нэр.